



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/008/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот  
2026 оны 02 дугаар сарын 23

2026

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: М.Алтантуяа

Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Энхзул

Утас: 99333147 Цахим хаяг: enkhzulg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.5.1 Завсрын аудитын талаар .....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	16
5.1 Албан шаардлага .....	16
5.2 Зөвлөмж .....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2026.02.23 № 2/30

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2025 онд улсын төсвийн санхүүжилтээр 603,971.1 мянга, нэмэлт санхүүжилтээр 36,429.3 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал

6426050087

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-  
албан тоот.docx

үйл ажиллагаанд 560,112.7 мянган төгрөгийг зарцуулж, 80,287.7 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ



**Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**  
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
33	<b>АВЛАГА</b>	0.00	68,674,192.81
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	68,674,192.81
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	13,674,946.00	15,035,546.00
351	<b>Түүхий эд материал</b>	7,265,300.00	7,265,300.00
35110	Тусгай зориулалттай материал	7,265,300.00	7,265,300.00
354	<b>Хангамжийн материал</b>	6,409,646.00	7,770,246.00
35410	Бичиг хэргийн материал	1,071,655.00	2,432,255.00
35420	Аж ахуйн материал	3,244,199.00	3,244,199.00
35450	Барилгын засварын материал	1,336,792.00	1,336,792.00
35470	Бусад хангамжийн материал	757,000.00	757,000.00
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>13,674,946.00</b>	<b>83,709,738.81</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	270,186,623.81	120,597,836.12
392	<b>Биет хөрөнгө</b>	258,986,623.81	119,097,836.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	140,831,731.84	0.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(24,272,134.42)	0.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	67,500,000.00	67,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(5,625,000.01)	(15,267,857.17)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	64,519,150.00	71,214,324.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,201,127.21)	(36,406,207.17)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	47,792,101.00	59,677,101.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,558,097.39)	(27,619,525.18)
393	<b>Биет бус хөрөнгө</b>	11,200,000.00	1,500,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,200,000.00	1,500,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>270,186,623.81</b>	<b>120,597,836.12</b>
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>283,861,569.81</b>	<b>204,307,574.93</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	0.00	2,922,869.72
413	<b>Өглөг</b>	0.00	2,922,869.72
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	2,322,869.72
4136	<b>Бусад өглөг</b>	0.00	600,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	600,000.00
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>2,922,869.72</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	283,861,569.81	201,384,705.21
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	283,861,569.81	201,384,705.21
51210	Өмнөх үеийн үр дүн	283,861,569.81	283,861,569.81
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	(82,476,864.60)
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>283,861,569.81</b>	<b>201,384,705.21</b>
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>283,861,569.81</b>	<b>204,307,574.93</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>556,735,807.50</b>	<b>628,394,311.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	472,464,700.00	593,191,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	472,464,700.00	593,191,000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	65,043,980.00	20,225,258.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	8,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	65,000,000.00	12,225,258.00

Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	43,980.00	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	19,227,127.50	14,978,053.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19,227,127.50	14,978,053.00
<b>12</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО</b>	<b>199,813,591.84</b>	<b>8,389,343.95</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	199,813,591.84	8,389,343.95
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	199,813,591.84	8,389,343.95
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>756,549,399.34</b>	<b>636,783,654.95</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>538,400,216.20</b>	<b>594,467,919.34</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	500,006,918.00	593,905,665.34
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	307,440,137.22	426,345,233.00
210101	Үндсэн цалин	189,440,153.00	264,001,502.00
210102	Нэмэгдэл	79,440,984.22	107,702,231.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,550,000.00	33,180,000.00
210104	Урамшуулал	15,009,000.00	21,461,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	38,251,531.88	52,946,736.39
210201	Тэтгэврийн даатгал	26,794,140.90	36,643,265.03
210202	Тэтгэмжийн даатгал	3,001,143.44	4,310,972.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,474,171.83	2,141,626.39
210204	Ажилгүйдлийн даатгал	1,396,414.76	1,970,174.25
210205	Эрүүл мэндийн даатгал	5,585,660.95	7,880,698.39
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,253,842.20	20,525,969.72
210301	Гэрэл, цахилгаан	2,244,474.00	2,889,568.12
210302	Түлш, халаалт	16,447,114.20	16,953,697.60
210303	Цэвэр, бохир ус	562,254.00	682,704.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	40,284,442.00	24,160,194.80
210401	Бичиг хэрэг	11,531,225.00	12,515,200.00
210402	Тээвэр, шатахуун	9,233,990.00	8,122,886.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,345,850.00	1,389,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,839,928.00	1,532,808.00
210408	Бараа материал акалсны зардал	1,733,449.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,606,999.00	0.00
210604	Урсгал засвар	8,606,999.00	0.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,980,000.00	2,000,000.00
210702	Дотоод албан томилолт	3,980,000.00	2,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	47,142,550.00	12,420,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,642,550.00	12,420,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	35,047,415.70	55,507,531.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,919,000.00	20,322,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,808,000.00	2,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,320,415.70	33,185,531.43
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	38,393,298.20	562,254.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	16,742,099.80	500,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,942,099.80	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,800,000.00	500,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	21,651,198.40	62,254.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,007,896.92	100.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,643,301.48	62,154.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>538,400,216.20</b>	<b>594,467,919.34</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>218,149,183.14</b>	<b>42,315,735.61</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,957,500.00	124,792,600.21
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	2,957,500.00	124,792,600.21

Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(2,957,500.00)	(124,792,600.21)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	215,191,683.14	(82,476,864.60)

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>556,735,807.50</b>	<b>628,394,311.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	472,464,700.00	593,191,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	472,464,700.00	593,191,000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	65,043,980.00	20,225,258.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	8,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	65,000,000.00	12,225,258.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	43,980.00	0.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	19,227,127.50	14,978,053.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19,227,127.50	14,978,053.00
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>556,735,807.50</b>	<b>628,394,311.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>514,997,807.50</b>	<b>628,394,311.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>475,404,509.30</b>	<b>559,157,864.19</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	306,012,837.22	426,345,233.00
210101	Үндсэн цалин	188,269,888.00	265,166,557.00
210102	Нэмэгдэл	79,184,140.22	107,702,231.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,549,809.00	33,109,664.00
210104	Урамшуулал	15,009,000.00	20,366,781.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	38,251,531.88	52,946,736.39
210201	Тэтгэврийн даатгал	26,794,140.90	36,643,265.03
210202	Тэтгэмжийн даатгал	3,001,143.44	4,310,972.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,474,171.83	2,141,626.39
210204	Ажилгүйдлийн даатгал	1,396,414.76	1,970,174.25
210205	Эрүүл мэндийн даатгал	5,585,660.95	7,880,698.39
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,253,842.20	18,328,000.00
210301	Гэрэл, цахилгаан	2,244,474.00	2,625,669.54
210302	Түлш, халаалт	16,447,114.20	15,019,626.46
210303	Цэвэр, бохир ус	562,254.00	682,704.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,545,840.00	7,721,160.80
210401	Бичиг хэрэг	3,600,000.00	4,515,800.00
210402	Тээвэр, шатахуун	5,999,990.00	795,152.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,345,850.00	1,302,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	1,107,808.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,392,000.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	792,000.00	0.00
210604	Урсгал засвар	5,600,000.00	0.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	3,980,000.00	2,000,000.00
210702	Дотоод албан томилолт	3,980,000.00	2,000,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	77,569,530.00	48,910,734.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	77,069,530.00	48,910,734.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	0.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	7,398,928.00	2,906,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,400,000.00	906,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,998,928.00	2,000,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39,593,298.20</b>	<b>69,236,446.81</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	17,942,099.80	500,000.00

Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,942,099.80	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	500,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>21,651,198.40</b>	<b>68,736,446.81</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,007,896.92	68,674,292.81
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,643,301.48	62,154.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)</b>	<b>514,997,807.50</b>	<b>628,394,311.00</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>41,738,000.00</b>	<b>0.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>41,738,000.00</b>	<b>0.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>41,738,000.00</b>	<b>0.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	41,738,000.00	0.00
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>41,738,000.00</b>	<b>0.00</b>
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(41,738,000.00)</b>	<b>0.00</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	68,669,886.67	68,669,886.67
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>68,669,886.67</b>	<b>68,669,886.67</b>
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	215,191,683.14	215,191,683.14
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	283,861,569.81	283,861,569.81
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>283,861,569.81</b>	<b>283,861,569.81</b>
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(82,476,864.60)	(82,476,864.60)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	201,384,705.21	201,384,705.21

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	/төгрөгөөр/
				Хувь
<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>603,971,100.00</b>	<b>524,516,707.19</b>	<b>79,454,392.81</b>	<b>86.84</b>
Татварын бус орлого	603,971,100.00	524,516,707.19	79,454,392.81	86.84
Тусламжийн орлого	603,971,100.00	524,516,707.19	79,454,392.81	86.84
Төсвөөс санхүүжих	603,971,100.00	524,516,707.19	79,454,392.81	86.84
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>603,971,100.00</b>	<b>524,516,707.19</b>	<b>79,454,392.81</b>	<b>86.84</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	603,971,100.00	524,516,707.19	79,454,392.81	86.84
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	603,471,100.00	524,516,707.19	78,954,392.81	86.92
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	473,692,300.00	411,396,010.00	62,296,290.00	86.85
Үндсэн цалин	268,132,300.00	265,166,557.00	2,965,743.00	98.89
Нэмэгдэл	111,521,100.00	92,753,008.00	18,768,092.00	83.17
Унаа хоолны хөнгөлөлт	56,110,600.00	33,109,664.00	23,000,936.00	59.01
Урамшуулал	37,628,300.00	20,366,781.00	17,261,519.00	54.13
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,324,300.00	52,946,736.39	6,377,563.61	89.25
Тэтгэврийн даатгал	40,368,500.00	36,643,265.03	3,725,234.97	90.77
Тэтгэмжийн даатгал	4,749,200.00	4,310,972.33	438,227.67	90.77

Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан				
ҮОМШӨ-ний даатгал	2,373,500.00	2141626.39	231,873.61	90.23
Ажилгүйдлийн даатгал	2,366,700.00	1970174.25	396,525.75	83.25
Эрүүл мэндийн даатгал	9,466,400.00	7,880,698.39	1,585,701.61	83.25
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,328,000.00	18,328,000.00	-	100.00
Гэрэл, цахилгаан	2,197,300.00	2,625,669.54	(428,369.54)	119.50
Түлш, халаалт	15,053,700.00	15,019,626.46	34,073.54	99.77
Цэвэр, бохир ус	1,077,000.00	682,704.00	394,296.00	63.39
Хангамж, бараа материалын зардал	12,362,000.00	7,721,160.80	4,640,839.20	62.46
Бичиг хэрэг	5,984,400.00	4,515,800.00	1,468,600.00	75.46
Тээвэр, шатахуун	795,200.00	795,152.80	47.20	99.99
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,587,500.00	1,302,400.00	2,285,100.00	36.30
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,994,900.00	1,107,808.00	887,092.00	55.53
Томилолт, зочны зардал	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
Дотоод албан томилолт	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,858,500.00	28,718,800.00	6,139,700.00	82.39
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,360,800.00	28,718,800.00	5,642,000.00	83.58
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	497,700.00	-	497,700.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	2,906,000.00	2,906,000.00	-	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	906,000.00	906,000.00	-	100.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00	500,000.00	-	100.00
Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	500,000.00	-	100.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	-	100.00
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.00
Төсвийн байгууллага	1	1	-	100.00
АЖИЛЛАГСДЫН ТОО	17	15	2	88.24
Удирдах ажилтан	1	1	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	13	11	2	84.62
Үйлчлэх ажилтан	3	3	-	100.00
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	17	15	2	88.24
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	14	12	2	85.71
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3	3	-	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>35,141,157.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>35,141,157.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	35,141,157.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	14,949,223.00
210102	Нэмэгдэл	14,949,223.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	20,191,934.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,191,934.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>35,141,157.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>35,141,157.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,949,223.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,191,934.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газар нь “Төрөөс баримтлах соёлын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, орон нутгийн онцлог хэв шинж бүхий соёлын өвд тулгуурлах хүн амыг соён гэгээрүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд оршино” гэсэн зорилгын дор үйл ажиллагаагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газар нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газар нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газар нь 2025 оны санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 204,307.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 79,554.0 буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	13,674.9	83,709.7	70,034.8
Авлага	0.0	68,674.2	68,674.2
Бараа материал	13,674.9	15,035.5	1,360.6
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	270,186.6	120,597.8	(149,588.80)
Үндсэн хөрөнгө	331,843.0	199,891.4	(131,951.60)
Хуримтлагдсан элэгдэл	(61,656.4)	(79,293.6)	(17,637.20)
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>283,861.5</b>	<b>204,307.5</b>	<b>(79,554.00)</b>
Өр төлбөр	0.0	2,922.9	2,922.90
Засгийн газрын хувь оролцоо	283,861.6	201,384.7	(82,476.90)
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>283,861.6</b>	<b>204,307.6</b>	<b>(79,554.00)</b>

Авлага дансны үлдэгдэл 68,674.2 мянган төгрөг нь төвлөрүүлэх шилжүүлгийг авлагаар тусгасан дүн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 15,035.5 мянган төгрөг болж 1,360.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсвийн худалдан авалтаар 43,553.5 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 42,192.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 199,891.4 мянган төгрөг болж 131,951.6 мянган төгрөгөөр буурсан нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2025 оны 06 дугаар сарын 12-ний өдрийн 7/40 дугаар тогтоолоор аймгийн Байгаль орчны газраас 3,575.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 11,885.0 мянган төгрөгийн тавилга, аж ахуйн эд хогшил, Соёл, спорт аялал жуулчлалын яамны Хөрөнгө оруулалтын газраас 3,120.0 мянган төгрөгийн компьютер шилжүүлэн авч, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 5/6 дугаар тогтоолоор Өрхийн эмнэлгийн 140,831.7 мянган төгрөгийн өртөг бүхий барилга, 9,700.0 мянган төгрөгийн өртөг бүхий газар шилжүүлсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,922.9 мянган төгрөг нь бараа үйлчилгээний бусад зардлын өглөг буюу 1,934.1 мянган төгрөгийн түлш халаалт, 263.9 мянган төгрөгийн гэрэл цахилгааны өглөг байна. Энэ нь Төсвийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор төсөв тодотгож, зардлын төсвөөс хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 201,384.7 мянган төгрөг болж 82,476.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 82,476.9 мянган төгрөгтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 771,505.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 167,534.0 мянган төгрөгөөр бууруулж 603,971.1 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 603,971.1 мянга, нэмэлт санхүүжилтээр 36,429.3 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 560,112.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 524,516.7 мянган төгрөг буюу 87.1 хувьтай байгаа нь байр цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 62,296.3 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 6,377.6 мянга, хангамж бараа материалын зардал 4,640.8 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 5,642.0 мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	573,471.1	499,658.7	73,812.4	87.13
2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	500.0	500.0	-	100.00
3	81569 Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	30,000.0	24,358.0	5,642.0	81.19
	Нийт дүн	603,971.1	524,516.7	79,454.4	86.84

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үр дүнг нэгтгэв.

Тус байгууллага нь “Хас эрин орчин” ХХК-ны 1,500.0 мянган төгрөгийн Dynamic санхүүгийн программ хангамжийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллага нь Засгийн газрын 2019 оны 6 дугаар тоот тогтоол, хөдөлмөрийн дотоод журмын 4.1.17 дахь заалтыг үндэслэн тайлант онд 56,110.6 мянган төгрөгийн хоолны зардал батлагдаж, гүйцэтгэлээр 33,109.7 мянган төгрөгийн хоолны зардлыг өдрийн 10.0 мянган төгрөгөөр тооцож олгосон байна.

Тус байгууллагын сургалт семинар зөвлөгөөнд зарцуулахаар 6 арга хэмжээний 51,996.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 5 арга хэмжээний 48,996.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Бүтэц орон тоог Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар удирдах 2, гүйцэтгэх 13, үйлчлэх 3 албан тушаалтны орон тоог баталсан бөгөөд тодотгосон төсвөөр төлөвлөлт, тайлагналт, мэдээлэл, цахимжилтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, зорилтот бүлгийн залуучууд, сургалт хариуцсан мэргэжилтэнгийн нийт 2 орон тоог цомхотгож, 88,494.6 мянган төгрөгийн цалингийн зардлын хэмнэлт үүссэн байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/217 дугаар “Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан, олон талт арга хэмжээнд оролцоход хөрөнгө зарцуулах тухай” захирамжаар 1,500.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/09 дугаар тушаалаар, аймгийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн А/440 дугаар “Олон улсын торгоны зам авто ралли уралдааны үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулах тухай” захирамжаар 5,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн А/22 дугаар тушаалаар, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн А/46 дугаар “Мөнгөн хөрөнгө зарцуулах, эрх шилжүүлэх тухай” тушаалаар 12,225.2 мянга, нүүдэлчин наадмын шилдэг өвлөн уламжлагч шагналд 1,500.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 19-ны өдрийн А/23 дугаар “Нүүдэлчин дэлхийн соёлын фестивалд оролцоход зардал гаргах тухай” 2025 тушаалаар, 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/25 дугаар тушаалаар тус тус зарцуулсан байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 04/28 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд болох босоо удирдлагатай улсын төсөвт байгууллагуудын төрийн захиргааны болон нийтлэг үйлчилгээний албан хаагчдад орон нутгийн төсвөөс албан хаагчдад 10 хувиар орон нутгийн нэмэгдэл тус тус олгохоор баталж 16,204.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн Б/12 дугаар тушаалаар 16,204.0 мянган төгрөгийн нэмэгдлийг олгосон байна.

Тайлант онд нийт 36,458.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, 33.3 мянган төгрөгийг улсын төсөвт, 1,254.8 мянган төгрөгийг орон нутгийн дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого

Байгууллагын нэр	Орлого
Баянхонгор аймгийн Засаг дарга	22,732.9
Монгол Улсын соёл, спорт, аялал, жуулчлал, залуучуудын яам	13,725.2
<b>Нийт дүн</b>	<b>36,458.1</b>

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд “РМВ” ХХК-иас 17,334.9 мянган төгрөгийн дулаанаар хангах гэрээ, “Цэвэр хот” ОНӨААТҮГ-тай хог хаягдал тээвэрлэх гэрээ, “Чандмань-Баянхонгор” ХК-тай цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах, дулааны эрчим хүчээр хангах үйлчилгээний гэрээ тус тус байгуулж ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхзул гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 1/04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2025 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг газрын дарга Б.Пүрэвдагва, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Мөнхтогтох нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны нийт батлагдсан төсөв 603,971.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,039.7 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 3,952.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2025 оны бичиг хэргийн зардлыг 1,468.6 мянга буюу 24.5%, шуудан холбоо, интернэтийн төлбөрийн зардлыг 2,285.1 мянган төгрөгөөр буюу 63.7%-иар хэмнэж ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2025 онд 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 166 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан бөгөөд 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 671,922.7 мянган төгрөгийн 16 гүйлгээ цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 124,451.3 мянган төгрөгийн 3 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 26,317.6 мянган төгрөгийн 7 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно аудит хийгээгүй.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Дорж гүйцэтгэж 8,926.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 670.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоосныг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 75 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	8,926.2	1	8,926.2	100%
Төлбөрийн акт	2	670.0	2	670.0	100%
Нийт дүн	3	9,596.2	3	9,596.2	100%

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 68,674.2 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Улсын төсөвт төвлөрүүлэх 68,674.2 мянган төгрөгийн шилжүүлгийг Сангийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 47 дугаар тушаалын дагуу авлагаар тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 4 дүгээр зүйлийн 4.1.1, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 1,703.6 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>2</sup> илэрснээс 1,703.6 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж, зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардлага өглөө.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 1,703.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2,249.2 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

#### 5.1 Албан шаардлага

5.1.1 Тайлант онд байгууллагын 3 албан хаагчид үндсэн цалингийн 40 хувьтай тэнцэх хэмжээний 1,703.6 мянган төгрөгийн ёс зүйн хорооны нэмэгдэл урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь "Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно" гэсэн заалтыг зөрчиж, уг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь "Төсвийн байгууллага, түүний албан тушаалтан", 3.2 дахь "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө" гэсэн заалттай нийцэхгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Шийдвэрлэсэн нь:** Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохгүй байх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

5.1.2 Сумдын Соёлын төвийн 10 байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байгууллагын дарга, нягтлан бодогчийн нэр зөрүүтэй, байгууллагын төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулсан тушаал шийдвэр, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ дутуу мэдээлсэн, хугацаа хоцроож мэдээлсэн зэрэг зөрчил илэрсэн байна. (Байгууллагын шилэн дансны зөрчлийн нэгтгэлийг хүснэгтээр оруулав.)

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5 дахь “Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргаа”, 6.4.5 дахь “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Дээрх мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нөхөн байршуулж, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд улирал бүр хяналт хэрэгжүүлж, 2026 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор хэрэгжилтийг ирүүлж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

Хүснэгт 5. Соёлын төвийн байгууллагуудын шилэн дансны зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Тушаал, шийдвэр		5 саяаас дээш орлогын		5 саяаас дээш зарлагын		Хугацаа хоцроосон		Нийт дүн
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	
<b>A</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>6</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>9</b>	<b>10</b>
1	Баацагаан сум	1	1,730.00							1,730.00
2	Баянговь сум	2	-	17	269,068.20	5	43,292.10			312,360.30
3	Баян-Овоо сум					1	11,202.00			11,202.00
4	Бууцагаан сум	5	2,405.00							2,405.00
5	Жаргалант сум			12	186,563.20	1	11,442.90	2	30,500.00	228,506.10
6	Хүрээмарал сум	3	-							-
7	Шинэжинст сум	7	-	4	44,810.70					44,810.70
8	Эрдэнэцогт сум			10	52,906.70	1	6,330.00	-	-	59,236.70
	<b>Нийт дүн</b>	<b>18</b>	<b>4,135.00</b>	<b>43</b>	<b>553,348.80</b>	<b>8</b>	<b>72,267.00</b>	<b>2</b>	<b>30,500.00</b>	<b>660,250.80</b>

9	Баянбулаг сум	Байгууллагын шилэн дансны цахим хуудаст төсөв захирагчийн мэдээлэл зөрүүтэй								
10	Жинст сум	Байгууллагын шилэн дансны цахим хуудаст нягтлан бодогчийн мэдээлэл зөрүүтэй								

## 5.2 Зөвлөмж

5.2.1 Байгууллагын нэр дээр бүртгэлтэй Фургон авто машины техникийн үзлэгт орох хугацаа дууссан байхад оношилгоонд хамрагдаагүй ба жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдаагүй, авто тээвэр б олон өөрөө явагч хэрэгслийн татварыг төлөөгүй байна.

Энэ нь Жолоочийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлий 4.1.3 дахь "Жолоочийн даатгалд даатгуулаагүй жолооч замын хөдөлгөөнд оролцохгүй байх" гэсэн заалтыг дагаж мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид байгууллагын байгууллагын нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслийг техникийн үзлэгт оруулж, албан татварыг хугацаанд нь төлж, алдааг дахин давтахгүй байх зөвлөмж өглөө.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
							Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Улсын төсөвт төвлөрүүлэх 68,674.2 мянган төгрөгийн шилжүүлгийг Сангийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 47 дугаар тушаалын дагуу авлагаар тусгаагүй байна.	1	68,674.2	1	68,674.2			1	68,674.2		
Дүн	1	68,674.2	1	68,674.2			1	68,674.2		

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд байгууллагын 3 албан хаагчид үндсэн цалингийн 40 хувьтай тэнцэх хэмжээний 1,703.6 мянган төгрөгийн ёс зүйн хорооны нэмэгдэл урамшуулал олгосон байна.	1	1,703.6			1	1,703.6		

**Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Байгууллагын нэр дээр бүртгэлтэй Фургон авто машины техникийн үзлэгт орох хугацаа дууссан байхад оношилгоонд хамрагдаагүй ба жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдаагүй, авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн татварыг төлөөгүй байна.	1	-					1	-	
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>1,703.6</b>				<b>1</b>	<b>1,703.6</b>	<b>1</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

*/мянган төгрөгөөр/*

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Сумдын Соёлын төвийн 10 байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байгууллагын дарга, нягтлан бодогчийн нэр зөрүүтэй, байгууллагын төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулсан тушаал шийдвэр, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ дутуу мэдээлсэн, хугацаа хоцроож мэдээлсэн зэрэг зөрчил илэрсэн байна.	1	-			1	-		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>			<b>1</b>	<b>-</b>		

-----oOo-----



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 44/АОС-1284/БНА-2026/008/НА-  
СТА-ТМЗ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд байгууллагын 3 албан хаагчид үндсэн цалингийн 40 хувьтай тэнцэх хэмжээний 1,703,600 (Нэг сая долоон зуун гурван мянган) төгрөгийн ёс зүйн хорооны нэмэгдэл урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь "Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно" гэсэн заалтыг зөрчиж, уг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь "Төсвийн байгууллага, түүний албан тушаалтан", 3.2 дахь "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө" гэсэн заалтыг дагаж мөрдөөгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал 2026 онд олгохгүй байх зөрчлийг

6426090143  
/documents/2026 он/1. бичиг  
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

арилгасан талаарх нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын дарга Б.Пүрэвдагва, нягтлан бодогч Б.Мөнхтогтох нарт даалгав<sup>1,2</sup>.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>3</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ  
АУДИТОР Г.ЭНХЗУЛ



<sup>1</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>2</sup> Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 45/АОСТ-1284/БНА-2026/008/  
НА-СТА-ТМЗ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумдын Соёлын төвийн 10 байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байгууллагын дарга, нягтлан бодогчийн нэр зөрүүтэй, байгууллагын төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулсан тушаал шийдвэр, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ дутуу мэдээлсэн, хугацаа хоцроож мэдээлсэн зэрэг зөрчил илэрсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5 дахь “Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргаа”, 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 дахь “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан

6426090147

/documents/2026 он/1. бичиг  
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Салбарын харьяа байгууллагуудын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст холбогдох мэдээллүүдийг нөхөн байршуулж, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд улирал бүр дотоод хяналт хэрэгжүүлж, нотлох баримтыг 2026 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын дарга Б.Пүрэвдагва, төсөв хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн А.Цэрмаа, нягтлан бодогч Б.Мөнхтогтох нарт даалгав<sup>1,2</sup>.

### АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>3</sup>:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

АУДИТОР

Г.ЭНХЗУЛ



<sup>1</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>2</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын  
2026 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн  
45/A0571284/ БНА-2026/008/НА-СТА-ТШЗ дугаар  
албан шаардлагын хавсралт

*/мянган төгрөгөөр/*

№	Байгууллагын нэр	Тушаал, шийдвэр		5 саяаас дээш орлогын		5 саяаас дээш зарлагын		Хугацаа хоцроосон		Нийт дүн
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	
A	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Баацагаан сум	1	1,730.00							1,730.00
2	Баянговь сум	2	-	17	269,068.20	5	43,292.10			312,360.30
3	Баян-Овоо сум					1	11,202.00			11,202.00
4	Бууцагаан сум	5	2,405.00							2,405.00
5	Жаргалант сум			12	186,563.20	1	11,442.90	2	30,500.00	228,506.10
6	Хүрээмарал сум	3	-							-
7	Шинэжинст сум	7	-	4	44,810.70					44,810.70
8	Эрдэнэцогт сум			10	52,906.70	1	6,330.00	-	-	59,236.70
	Нийт дүн	18	4,135.00	43	553,348.80	8	72,267.00	2	30,500.00	660,250.80

9	Баянбулаг сум	Байгууллагын шилэн дансны цахим хуудаст төсөв захирагчийн мэдээлэл зөрүүтэй								
10	Жинст сум	Байгууллагын шилэн дансны цахим хуудаст нягтлан бодогчийн мэдээлэл зөрүүтэй								

-----oOo-----